

## Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 11 дүгээр сарын байдлаар)

### I. Нийгмийн үзүүлэлт




#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны 11-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 572 болж, 2014 оны мөн үеэс 26 хүнээр өсч, өмнөх сарынхаас 546 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 52.1 хувь буюу 298 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 1675 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 1020 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 39.31 хувь буюу 401 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1

**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 11 дүгээр сарын эцсийн байдлаар**



Тайлант сард бүртгүүлсэн 206 ажилгүй иргэний 23.3 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 16.99 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 16.99 хувь нь шилжин суурьшсан; 13.59 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 6.31 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 5.83 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй

эрсдэлд орж орлогогүй болсон; 3.4 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 2.43 хувь нь байгууллага татан буугдсан; 1.94 хувь нь орон тооны цомхтголд орсон; 1.46 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.97 хувь нь цэргээс халагдсан; 0.49 хувь нь хорих газраас суллагдсан; 6.31 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар**



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



#### I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 11 сард НДШ-ийн орлого 12.8 тэрбум ₮ болж төлөвлөгөө 85.75 хувь болж, төлөвлөгөөг 10 сум 2.21-10.25 хувиар давуулан биелүүлж, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баян, Баянжаргалан, Баянцогт, Борнуур, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод сумд 37.44-0.45 хувиар

тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 958.1 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжид 33.8 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.3 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.3 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 257350 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 33.83 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 23.14%; тэтгэмжийн даатгалын сангийн 98.44%; эрүүл мэндийн даатгалын сангийн 93.90%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 149.95%; ажилгүйдлийн даатгалын сангийн 134.95%-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 11 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 52716 хүнд олгож, 9.3 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 5.7 хувь 2866 хүнээр өсч, зарцуулсан мөнгөний хэмжээ 3.4 хувь 309.6 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 107640 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 32.0 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 27.9 хувийг халамжийн тэтгэвэр; 10.2 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 7.5 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.5 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 5.6 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож


байгаа хөнгөлөлт, тусламж 1.1 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.



### 1.3 Эрүүл мэнд

2015 оны эхний 11 сард 13350 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.54 ор хоног ногдлоо.


Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 11 сард 1161 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 68 хүүхдээр буурлаа.



Он гарсаар 1-4 хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 4 хүүхдээр өслөө.

Эмнэлгийн мэдээгээр 2015 оны эхний 11 сард 418 хүн нас барсан нь 2014 оны мөн үеэс 18.4 хувиар өслөө. Нас барсан хүний 12.2 хувь буюу 51 нь эмнэлэгт нас баржээ. Нас баралтыг шалтгаанаар аваад үзвэл хорт хавдарын нас баралт хамгийн өндөр 23.0 хувь, гадны шалтгаан 12,9 хувийг эзлэв.

2015 оны эхний 11 сард нийт гарсан халдварт өвчнөөр 1095 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1.4 дахин буюу 633 хүнээр өслөө. 2014 оны мөн үеэс салхин цэцэг 2 дахин, цусан суулга 1.1 дахин, тэмбүү 28.6 хувь, гахай хавдар 28.6 хувь, сүрьеэ 19.1 хувь, бусад өвчлөл 4.1 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 122 байгаа бол: Зуунмод 388, Баянжаргаланд 204 ногдлоо.



### 1.4 Байгаль орчин

#### Төв аймгийн 2015 оны 11 сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

-агаарын дундаж температур -9-16 градус хүйтэн, Баянцагаан, Дэлгэрхаан орчмоор дулаан, нутгийн зүүн хэсэг, Мөнгөнморьт хамгийн хүйтэн байв.

- өдрийн агаарын хамгийн их температур нь 9,0-17,0 градус дулаан, нутгийн зүүн болон зарим газраар

хүйтэн, Мөнгөнморьт, Угтаал орчмоор хамгийн хүйтэн, баруун өмнөд хэсгээр дулаавтар, Бүрэн, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Эрдэнэсант орчмоор 15,0-17,0 градус дулаан байв.

-шөнийн хамгийн бага температур 30-39 градус хүйтэн буюу Дэлгэрхаан, Баянцагаан орчмоор хүйтний эрч сулавтар 30 градус, нутгийн зүүн хэсэг, томоохон голын хөндий дагуух нутгууд Бүрэн, Алтанбулагт 39 градус хүрч хүйтэрлээ.

-сарын нийлбэр тунадас 2,3-10,4 мм, нутгийн зүүн өмнөд хэсгээр бага буюу Баянцагаан, Дэлгэрхаан, Мөнгөнморьт орчмоор хамгийн бага 2,3-3,8 мм, нутгийн баруун хойд буюу төв хэсгээр арай ахиу буюу хамгийн их нь Заамарт 10,4 мм, Нөхөрлөлд 10,1 мм, Эрдэнэсантад 9,9 мм цас орж, одоогийн байдлаар нийт нутгаар 2-20 см зузаан цастай байна. / өртөө харуулын талбай дээрх хэмжилтээр /

- Салхи ихэнх хугацаанд баруунаас 1-6 м/с, цас орох үеэр зарим газраар 6-11 м/с, түр зуур 16-18 м/с хүрч ширүүслээ. Аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн хүчтэй салхи шуурга болоогүй байна.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

2015 оны 11-р сарын цаг агаарын үзүүлэлтүүдийг 2014 оны 11-р сартай харьцуулахад:

-агаарын дундаж температур ихэнх нутгаар 2,6-5,6 градусаар хүйтэн

-өдрийн хамгийн их температур нь нийт нутгаар 1-5 градус орчмоор дулаан буюу ойролцоо

-шөнийн хамгийн бага температур өмнөх оноос бүх нутгаар 4-16 градусаар хүйтэн байна.

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд нийт нутгаар / Жаргалантаас бусад / өмнөх 11-р сараас 0,6-9,3 мм-ээр ахиу цас оржээ.

- Сарын эхээр ихэнх өдрүүдэд өмнөх оноос нийт нутгаар дулаавтар, цас багатай байсан ч, хугацааны дунд үеэс цас орж, хүйтэрсэн байна. Цаашид дээрх нутгуудаар цасны зузаан улам нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн 12-р сарын дунд үе, эцсээр хүчтэй цасан шуурга шуурч малын хариулга маллагаанд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

#### ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

12 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр нутгийн хойд хагас болон Баруун хуурай, Хонин-Усны хоолой болон Алтайн Өвөр говиор дунджаас бага зэрэг хүйтэн, бусад нутагт дунджийн орчим, цас ихэнх нутагт дунджийн орчим, Хангайн нурууны , Хөвсгөлийн уулархаг нутаг, Эрээний нуруу, Хэрлэн голын сав дагуух нутаг болон говийн нутгийн өмнөд хэсгээр дунджаас ахиу орохоор байна.

Одоогийн байдлаар нийт нутгийн 80 гаруй хувьд цасан бүрхүүл тогтсоноос ихэнх нутагт 0-6 см зузаан буюу нягт нь 0,02-0,26 гр/см<sup>3</sup>, Увс, Завхан, Төв, Сүхбаатарын ихэнх, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий,

Дундговь, Дорноговийн зарим сумдын нутагт 7-12 см зузаан буюу нягт нь 0,02-0,27 гр/см<sup>3</sup>, Увсын Улаангом, Хөвсгөлийн Цагаан-Үүр, Завханы Яруу, Баянхайрхан, Булганы Рашаант, Баянхонгорын Жаргалант, Төвийн Жаргалант сумдад 13-22 см зузаан цастай буюу нягт нь 0,12-0,18 гр/см<sup>3</sup> байна. Цаашид цас их орж, цасны зузаан улам нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн үе үе хүчтэй цасан шуурга шуурч малын хариулга маллагаа болон зам тээврийн ажилд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

#### 2015 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын температурын дундаж нь Туул голын хөндийгөөр 25-30 градус, аймгийн баруун өмнөд хэсгээр 11-16 градус, бусад нутгаар 18-23 градус хүйтэн буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

#### 1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 11 сард аймгийн хэмжээнд 821 гэмт хэрэг бүртгэгдэж 833 хүн холбогдож иргэдийн өмчид 2.97 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.




Гарсан гэмт хэргийн 45.3 хувь нь хулгай, 27.4 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 14.6 хувь нь замын осол, 3.9 хувь нь танхай дээрэм, 1.0 хувь нь хүн амины хэрэг, 0.1 хувь нь өмчийн, 7.7 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Аргалант, Баян,

Баяндэлгэр, Заамар сумд 18 дээш насны 10000 хүнд 747-187 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (136)-аас харьцангуй их гарлаа.

Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 83 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 40 эмэгтэй, 1020 эрэгтэй нийт 1060 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 18 хүнээр өслөө. 413 хүн баривчлагдлаа.

10000 хүнд ноогдох гэмт хэргийн тоог газрын зургаар харуулвал.



Гарсан гэмт хэргийн 23.9 хувь нь бүлгээр; 20.5 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 355 хүн гэмтэж, 64 хүн нас барлаа.

## Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 11 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 805 гүйцэтгэх хуудсанд нийт 3.35 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 42 гүйцэтгэх хуудсанд ногдох 704.1 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 763 гүйцэтгэх хуудасны 2.65 тэрбум ₮-өөс 423 хуудасны 1.16 тэрбум ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 55.44 хувь, үнийн дүнгээр 43.90 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 1.77 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 28.34 нэгжээр тус тус буурлаа.





## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 11 сард кассын орлого 375.9 тэрбум ₮, кассын зарлага 374.9 тэрбум ₮ болж, гүйлгээнд 1.2 тэрбум ₮ байна.


ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны эхний 11 сарын байдлаар 117.4 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 670.3 сая ₮-өөр буурлаа. 2015 он гарсаар бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 110.3 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.37 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.91 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



### II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 11 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 11.1 тэрбум ₮, зарлага 54.8 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 102.77 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Хувь хүний орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, бусад төлбөр, хураамж, хүү торгуулийн орлого, төсөвт газрын өөрийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, төрийн өмч худалдсаны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.



Аймгийн төсвийн орлого 2014 оны мөн үеэс 2.2 хувь буюу 240.7 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 85.7 хувийг татварын, 12.8 хувийг татварын бус, 1.4 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оны мөн үеэс татварын орлого 1.5 нэгжээр өсч, татварын бус орлого 2.6 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 1.0 нэгжээр өслөө.


Аймгийн нийт 3 шатны орлого 14.8 тэрбум ₮ болж аймгийнх 9.1 тэрбум ₮ буюу 61.34 хувь, сумынх 2.0 тэрбум ₮ буюу 13.70 хувь, улсынх 3.7 тэрбум ₮ буюу 24.96 хувийг тус бүр бүрдүүлжээ.



### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2015 оны 11 дүгээр сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 60.94%, өмнөх оны мөн үеэс 6.67%, өмнөх сараас 1.38 хувиар тус тус өсөв.

Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эхнээс, хувиар



Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 11 дүгээр сарын 1.31 хувийн

өсөлтийн 0.71 нэгж (51.69%) нь хувцас, бөс барааны бүлгийн, 0.27 нэгж (19.80%) нь тээврийн бүлгийн, 0.19 нэгж (13.50%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн, 0.18 нэгж (12.87%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн, 0.04 нэгж (2.94%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн, 0.03 нэгж (2.44%) нь амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн өсөлтөөс тус тус шалтгаалав.

Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 11 сард	
	пунктээр	хувиар
<b>Бүгд</b>	<b>1.38</b>	<b>100.00%</b>
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.04	2.94%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.71	51.69%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.19	13.50%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.18	12.87%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.27	19.80%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.04	-3.23%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.03	2.44%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%



## II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2015 оны эхний 11 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 37.13 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 0.96 хувь буюу 18.19 тэрбум ₮-өөр өслөө.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Баянчандмань, Жаргалант, Зуунмод, Баянцогт, Баянцагаан сумд 47.23-2.73 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 95.29) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.₮  
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2014	2015	2014	2015	Дүнд эзлэх % Percentage share to total		2015% 2014%
	XI	XI	I-XI	I-XI	2014 I-XI	2015 I-XI	
Нийт дүн	1,596.11	5,322.17	18,943.54	37,133.04	100.0	100.0	196.0%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	1,162.88	4,895.47	11,631.90	30,971.67	61.40%	83.41	266.3%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	214.89	232.61	5,854.26	4,812.05	30.90	12.96	82.2%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	218.34	194.08	1,457.39	1,349.32	7.7	3.63	92.6%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, нийтлэх хэвлэх дуу бичлэг хийх үйл ажиллагаа, ариутгал, ус хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 1.89 дахинаас-0.2 хувь буюу 19.73 тэрбумаас -0.01 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 11 сарын нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 3.63, боловсруулах үйлдвэрлэл 12.96 ашигт малтмал олборлолт 83.41 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 11 дугаар сарын байдлаар, хувиар



## II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2015 оны эхний 11 сард 5.2 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 1.5 дахин буюу 7.9 тэрбум ₮-өөр буурав.


Барилга угсралт, их засварын ажлын 56.8 хувь нь инженерийн барилга байгууламжид; 38.54 хувь нь орон сууцны бус барилгад; 4.66 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2014 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны барилгын ажил 5.38 пунктээр; инженерийн барилга байгууламжийн ажил 8.81 пунктээр тус тус буурч; орон сууцны бус барилгын ажил 14.18 пунктээр өсөв.

Зураг II.1

### Барилгын ажлын гүйцэтгэл,

жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар,

сая төгрөгөөр




## II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 11 сард 184.9 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 83.2 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.53 хувь буюу 70.2 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 85.8 сая ₮ болсон ба нийт орлогын 77.69 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 22.30 хувийг албан бичгийн, 11.92 хувийг зорчигчдын, 65.78 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 11 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр





## **Стандартчилал хэмжилзүй**

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2015 оны эхний 11 сарын мэдээгээр нийт 280 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 484; үүнээс тохирлын гэрчилгээ 409, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 75; цулын хэмжүүр 1182, үүнээс жин 960, туухай 207, автомашины жин 7; тунагч 8; эзлэхүүний хэмжүүр 426, үүнээс түгээгүүрийн хошуу 335, сүмбэн метр 52, усны тоолуур 20; шигэн бүтээгдэхүүн хэмжих хэрэгсэл 12, мерник 1, цахилгааны хэмжүүр 2312, үүнээс нэг фазын тоолуур 2108, гурван фазын тоолуур 204, даралтны аппарат 64 тус бүр баталгаажуулсан байна.

### **Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.**

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 11 сард нийт 891 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 39; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 391; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 1; бэлэглэлийн гэрээ 35; худалдах, худалдан авах гэрээ 32; өв залгамжлал 14; барьцааны гэрээ 205; бусад бүртгэл 173 тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2015 оны эхний 11 сард нийт 173 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 118;

нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 23; гишүүдэдээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 6; Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/ 1; хоршоо 7; төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар /ТБАГУТҮГ/ 2; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 13; банк бус санхүүгийн байгууллага 2 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2015 оны 11 сарын мэдээгээр 287 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 61; гишүүн нэмэгдсэн 61; данс нэмэгдсэн 18; дүрэм шинэчилсэн 10; дахин гэрчилгээ авсан 30; удирдлага өөрчлөгдсөн 20; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 22; дүрмийн сан нэмэгдсэн 12; нэгдсэн 1; хаяг өөрчлөгдсөн 15; татан буугдсан 31; нэр өөрчлөгдсөн 5; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүллээ.